

**Улсын Их Хурлын Тамгын Газар  
Судалгааны хэлтэс**

Код: СТ-16/204

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОЛОН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН  
ТӨЛБӨР, ТӨЛБӨР ТОГТООХ ҮНДЭСЛЭЛ, СУРГАЛТЫН ДЭМЖЛЭГИЙН ТАЛААРХ  
МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА,  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан мэдээлэл, лавлагаа )

**Гүйцэтгэсэн судлаачид:**

Ө.Мөнхтунгалаг  
О.Нарантуяа  
Б.Нандингэрэл  
И.Жаргалзаяабямба

**Улаанбаатар  
2016**

## Агуулга

**Нэг. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын төлбөрийн хэмжээ, сургалтын төлбөр тооцох үндэслэл болон холбогдох эрх зүйн орчин**

- 1.1. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох, төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин
- 1.2. Төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоож буй үндэслэл

**Хоёр. Гадаадын зарим орны ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөр тогтоох, сургалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин**

2.1.АНУ

2.2.Их Британи

2.3.Австрали

2.4.БНСУ

### **Хавсралт 1:**

*Монгол Улсын төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий болон их, дээд сургуулиудын төлбөрийн мэдээлэл*

### **Судалгааны үр дүн:**

Судалгааны сэдвийн хүрээнд ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, сургалтын төлбөр тогтоох үндэслэл ба аргачлал, суралцагчдад төрөөс үзүүлж буй дэмжлэгтэй холбоотой асуудлыг Монгол Улс болон өндөр хөгжилтэй гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын хүрээнд хайлт хийж судлан, дараах мэдээллийн хүрээнд мэдээлэл лавлагаа бэлтгэсэн болно. Үүнд:

- Монгол Улсын Боловсролын салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоох аргачлал, үндэслэл болон суралцагчдад төрөөс үзүүлж буй дэмжлэгтэй холбоотой асуудлыг “Боловсролын тухай” хууль, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудын хүрээнд судалсан болно. Зарим мэдээллийг Боловсролын яамнаас гаргуулан авч судалгаанд хавсаргав.
- Гадаадын зарим орны /АНУ, Австрали, Их Британи, БНСУ/ ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын төлбөр тогтоож буй аргачлал, үндэслэл, оюутны сургалтын тэтгэлэг, дэмжлэг, зээлийн харилцааг зохицуулахтай холбоотой асуудлыг тухайн улс орнуудын боловсролын салбарын эрх зүйн зохицуулалтын актууд болон интернетийн эх сурвалжид тулгуурлан судалсан болно.

Судалгаанаас үзэхэд,

- Монгол Улсын хууль тогтоомжоор эрх бүхий байгууллагуудаас гаргасан журам, аргачлалын дагуу тухайн сургуулийн Удирдах зөвлөл нь сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох эрхтэй. Сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн жилийн инфляцийн түвшин, үйл ажиллагааны зардлын болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоодог байна. Их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо 1 оюутны тухайн жилд сонгосон кредит цагаас шалтгаалан харилцан адилгүй тогтоодог байна. Сургалтын төлбөрийн 1 кредитийн үнэлгээг шинэчлэн тогтоохдоо сургуулийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үндэслэдэг бөгөөд багш нарын цалин, практик хичээлийн зардал, судалгаа шинжилгээний ажлын зардал зэрэг сургалт судалгаатай холбоотой зардал, оюутны үйлчилгээний зардал, шууд бус зардал зэргийг тооцон тогтоодог байна.
- Их Британид Дээд боловсролын тухай хуулиар оюутны төлбөрийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталдаг байна. Тухайлбал, Дээд боловсролын тухай хуулийн 3-р бүлгийн 24 зүйлд зааснаар, Английн Дээд боловсролын санхүүгийн зөвлөл, сургуулийн дэргэдэх Хөгжлийн агентлагын зөвлөлийн шийдвэрээр (*өөрөөр хэлбэл Оюутны санхүүжилтийн газар*) оюутны төлбөр, нөхцөл, тэтгэлэг, зээлийн асуудлуудыг шийднэ гэж заажээ.
- Австрали Улсад улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлбөрийг тогтоохдоо үндсэн үзүүлэлт болох тухайн сургуульд нэг жилд суралцах сурагчийн тоо, нэг сурагчид ноогдох хуулиар тогтоосон санхүүжилтийн хэмжээ, тухайн сургуульд үзүүлж буй олон нийтийн санхүүгийн дэмжлэг, бусад үзүүлэлт болох хөгжлийн бэрхшээлтэй сурагчид, уугуул болон Торрес арлын сурагчид, амьжиргааны түвшин доогуур сурагч, төрөлжсөн биш энгийн сургууль, бага хүчин чадалтай сургууль зэргийг харгалзан тогтоохоор хуульчилсан.
- АНУ-д төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежуудын сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоох аргачлал зэргийг Холбооны улсын муж болгон өөр өөрсдийн хуулиар зохицуулах ба тухайн сургууль нь сургалтын үйл ажиллагааны дүрэм, журмаараа энэхүү асуудлыг зохицуулна. Ингэхдээ мэргэжлийн байгууллагаас жил бүр гаргадаг боловсролын үнийн индекс *Higher Education Price index*-ийг харгалзан үзэхийг зөвлөмж болгодог байна.
- БНСУ-д Боловсрол, шинжлэх ухаан, технологийн яамнаас баталсан “Их сургуулийн сургалтын төлбөрийг тогтоох журам”-д заасны дагуу Сургалтын төлбөрийн хяналтын хороо ажилладаг. Сургалтын төлбөрийн хяналтын хороо нь сургууль тус бүр дээр хуульд заасны дагуу сургалтын болон бусад шаардлагатай төлбөрийг тооцож гаргах чиг үүрэгтэй ажилладаг. Тус журмаар сургалтын төлбөрийг тооцохдоо жилийн дундаж сургалтын төлбөр дээр үндэслэн тухайн жилийн инфляцийн түвшин, зардлын өсөлт, бууралтыг харгалзан бакалавр, магистр, докторын сургалт тус бүрээр тооцож гаргасны дагуу салбарын сайд баталдаг. Хяналтын хорооны ажиллах хугацааг тухайн сургуулийн журмаар тогтоох бөгөөд ихэвчлэн 1 жил ажиллахаар тогтоосон байдаг. */Дэлгэрэнгүй мэдээллийг судалгаанаас үзнэ үү./*

*Жич: Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд сургалтын төлбөрийн хэмжээг боловсролын чанарын үзүүлэлттэй уялдуулан тогтоодог аргачлал бий эсэх талаар тодорхой мэдээлэл олдоогүй болно.*

**Нэг. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын төлбөрийн хэмжээ, сургалтын төлбөр тооцох үндэслэл болон холбогдох эрх зүйн орчин**

1.1. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох, төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин

Монгол Улсад 2016 оны байдлаар нийт 100 их дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс төрийн өмчит 17, хувийн хэвшлийн 78, гадаадын 5 салбар сургууль дээд боловсролын үйлчилгээ үзүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор төрийн өмчийн 42 их, дээд сургуулийг 16 болгон өөрчлөн зохион байгуулсанаар магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо буурсан байна. Түүнчлэн ерөнхий боловсролын улсын 590, хувийн хэвшлийн 99 сургууль үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 7-д төрөөс бүх нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгохоор заасан. Үүнтэй уялдуулан Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай зэрэг хуулиудаар салбарын эрх зүйн харилцааг зохицуулжээ. Үүнээс суралцагчдын сургалтын тэтгэлэг болон хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой асуудлыг дараахь хууль тогтоомжуудаар зохицуулж байна.

*Хүснэгт 1*

**Оюутан, сурагчдад сургалтын тэтгэлэг, дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулсан хуулиуд**

<b>Хууль тогтоомжийн нэр</b>	<b>Шийдвэрийн огноо, дугаар</b>	<b>Тэтгэлгийн талаарх зохицуулалт</b>
Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль	Монгол Улсын хууль 2011 он	Энэхүү хуулиар суралцагчдад үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зорилго, зохион байгуулалт, дэмжлэгийн хэлбэр, хамрагдах нөхцөл боломж, санхүүжилт, хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан 5 бүлэг, 15 зүйлтэй.
Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 78 дугаар зарлиг	Дэлхийд зэрэглэлээрээ эхний 20-д багтсан сургуулиудад суралцагчдын хүсэлтийг үндэслэн, суралцаж буй мэргэжлийн чиглэлийг харгалзахгүйгээр санхүүжилт олгох, 2. Дэлхийд зэрэглэлээрээ 21-100-д багтсан сургуулиудад суралцагчид Монгол Улсын Засгийн газраас зарласан мэргэжлийн чиглэлийг харгалзан, суралцагчдын хүсэлтийг үндэслэн санхүүжилт олгох,
Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам	ЗГ-ын 2012 оны 19 дүгээр тогтоол 4 дүгээр хавсралт	Энэхүү журмаар - Сургалтын төлбөрийн зээл - Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг олгохоор журамласан.

<p>Монгол Улсын болон гадаадын боловсролын сургалтын байгууллагад суралцагсдад төрийн буцалтгүй тусламж олгох тухай</p>	<p>ЗГ-ын 2008 оны 117 тогтоол</p>	<p>Буцалтгүй тусламж үзүүлэх нөхцөл:  - Улсын хэмжээний олимпиадад эхний 3 байр эзэлсэн сурагчийн сургалтын төлбөрийг  - Олон улсын зэрэглэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн амжилттай оролцсон суралцагчийн сургалтын төлбөр;  - Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа Монгол Улсын иргэний амьжиргааны тэтгэлэг;  - Бүтэн өнчин суралцагчийн сургалтын төлбөр;  - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын төлбөр;  - Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөр;  - Өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бүсийн амьжиргааны түвшингийн 50 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагчийн сургалтын төлбөр;  - Бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 50 хүртэл толгой мал ногдох малчин өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөр;  - Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэний сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг.</p>
<p>Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам</p>	<p>ЗГ-ын 2013 оны 271 тогтоол</p>	<p>Энэхүү журмын дагуу олгож байгаа сургалтын зээл нь хөнгөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.  Дэлхийн шилдэг их сургуулийн эхний 20-д багтсан их сургуулийн суралцагч мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр, 21-100-д багтсан их сургуульд Засгийн газраас баталсан мэргэжлийн чиглэлээр суралцагч сургалтын зээлд хамрагдах хүсэлт гаргах эрхтэй.</p>
<p>Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам</p>	<p>ЗГ-ын 2014 оны 71 тогтоол</p>	<p>Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын диплом, бакалавр, магистр, докторын боловсрол эзэмших өдрийн ангид болон хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн, хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд тус тус сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийг олгоно.</p>

Суралцагчдад төрөөс санхүүгийн дэмжлэг олгох, дэмжлэг авсан суралцагчдын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг Сургалтын төрийн сан хариуцан ажилладаг.

Мэргэжлийн хяналтын байгууллагуудаас Засгийн газраас баталсан Боловсролын хяналтын дүрмийн дагуу боловсролын тухай хууль тогтоомж, бага, дунд болон

мэргэжлийн боловсролын стандарт, сургалтын байгууллагын ажлын түвшин, түүнтэй холбогдсон норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<sup>1</sup> Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанар, үнэлгээг хянаж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Боловсролын үнэлгээний төв ажилладаг.

Монгол Улсын төрөөс их, дээд сургуульд суралцагчдад дараахь төрлийн сургалтын төлбөрийн дэмжлэг туслалцааг үзүүлж байна. Үүнд:

### **1. Хөнгөлөлттэй зээл:**

Элсэлтийн ерөнхий шалгалтад 600 ба түүнээс дээш оноо авсан шинэ элсэгч, голч нь 2,8 ба түүнээс дээш дүнтэй суралцаж байгаа дараахь суралцагчдад;

1. Хагас өнчин суралцагч;
2. Малчин өрхийн суралцагч;
3. Өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч;
4. Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч.

### **2. Урамшууллын тэтгэлэг:**

Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад сурлагын өндөр амжилт гаргасан болон эрэлт ихтэй мэргэжлээр өдрийн ангид амжилттай суралцаж байгаа суралцагчдад **урамшууллын тэтгэлэг** олгоно.

Үүнд: Засгийн газраас баталсан 20 мэргэжил хамаарна.

- 3.6 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа диплом, бакалаврын зэргийн суралцагчид 50 хувийн;
- 3.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа диплом, бакалавр, магистр, докторын зэргийн суралцагчид 75 хувийн;
- Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулсан улсын олимпиадад эхний гурван байранд шалгарсан шинээр элсэгчид 100 хувийн;
- Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олон улсын олимпиадад оролцож, шагналт байранд шалгарсан шинээр элсэгчид 100 хувийн.

### **3. Үндэсний тэтгэлэг:**

Монгол Улсын аттестатчлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элсэж, суралцах чадвар, идэвх санаачилга, төлөвшлөө илтгэн харуулсан **өдрийн ангийн** суралцагчдад **үндэсний тэтгэлэг** олгоно. Үндэсний тэтгэлэгийг 10 сарын турш, сар бүр 70.200 төгрөг олгож байгаа.

### **4. Сургалтын төлбөр:**

- Бүтэн өнчин бакалаврын зэргийн суралцагч;
- Хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын зэргийн суралцагч;

---

<sup>1</sup> Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 37 зүйл

- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын зэргийн нэг суралцагчид.

## 5. Нэрэмжит тэтгэлэг:

Аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэн болон сургалтын байгууллага тодорхой нөхцөл, болзол хангасан суралцагчид өөрийн нэрэмжит тэтгэлэг олгож болох бөгөөд уг тэтгэлэгийн болзол, нөхцлийг тэтгэлэг олгогч этгээд тогтооно. Нэрэмжит тэтгэлэг олгодог байгууллагууд нь: Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын нэрэмжит, Хаан болон Голомт банк, Зориг сан, Оюу-Толгой, Монголын Оюутны холбоо, Швейцарын хөгжлийн агентлаг гэх мэт.

## 6. Тухайн сургуулийн тэтгэлэг:

Суралцагчийн суралцаж буй сургууль тодорхой шалгуур хангасан оюутнуудад өөрийн сургуулийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг олгодог. Тухайлбал: МУИС-ийн нэрэмжит 6 төрлийн тэтгэлэг, ШУТИС-ийн “Ректорын нэрэмжит тэтгэлэг”, Мандах бүртгэл дээд сургуулийн тэтгэлэг гэх мэт.

Орон нутгийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг хангах зорилгоор нутгийн захиргааны байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад зориулсан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд уг дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

## 7. Гадаадад суралцагчдад олгох тэтгэлэг:

Гадаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа Монгол Улсын иргэнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл олгож болно. Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно. Суралцагчид олгох сургалтын зээлийн нийт хэмжээ нь суралцагчийн суралцах хугацааны сургалтын төлбөр, амьжиргааны зардлын нийлбэрээс хэтрэхгүй байх бөгөөд сургалтын зээлийг буцаан төлүүлэхдээ зээлдэгчийн амьжиргаанд нь дарамт үүсгэхгүйгээр суутгал хийхээр хуульчилсан.

*Хүснэгт 2*

**2015-2016 оны хичээлийн жилд амьжиргааны түвшин доогуур өрхөөс суралцаж буй оюутнуудад сурлагын амжилтыг нь үндэслэн тэтгэлэг, хөнгөлөлт үзүүлсэн талаарх мэдээлэл <sup>2</sup>**

№	Сургуулийн нэр	Оюутны тоо	Тэтгэлэг, хөнгөлөлтийн хэмжээ	Тайлбар
1	Монгол Улсын их сургууль	208	127,100,000.0	Зарим оюутанд зохих хөнгөлт үзүүлдэг, заримд нь бүтэн тэтгэлэг олгодог
2	Шинжлэх ухаан, технологийн их сургууль	23	13,000,000.0	Зарим оюутанд зохих хөнгөлт үзүүлдэг, заримд нь бүтэн тэтгэлэг олгодог
3	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	243	227,000,000.0	Зарим оюутанд зохих хөнгөлт үзүүлдэг, заримд нь бүтэн тэтгэлэг олгодог

<sup>2</sup> Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамнаас ирүүлсэн мэдээлэл, 2016.04.15

4	Боловсролын их сургууль	их	20	20,000,000.0	Янз бүр байна
5	Монгол-Германы хамтарсан технологийн их сургууль		20	75,000,000.0	Янз бүр байна
6	Хөдөө аж ахуйн их сургууль		61	28,365,000.0	Янз бүр байна
7	Соёл, урлагийн их сургууль		13	14,957,000.0	Янз бүр байна
8	Дорнод их сургууль		37	12,800,000.0	Янз бүр байна
9	Их засаг их сургууль		50	280,000,000.0	Янз бүр байна
10	Отгонтэнгэр их сургууль	их	62	59,535,000.0	Янз бүр байна
11	Этүгэн их сургууль		15	15,000,000.0	Янз бүр байна
12	Монголын үндэсний их сургууль		183	124,893,000.0	Янз бүр байна
<b>Дүн</b>			<b>935</b>	<b>997,650,000.0</b>	

## **1.2. Төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоож буй үндэслэл**

*Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.4-д зааснаар тухайн сургуулийн Удирдах зөвлөл нь сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох эрхтэй. Сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн жилийн инфляцийн түвшингээс хэтрүүлэхгүй байхаар салбар яамнаас чиглэл өгдөг ба өгсөн чиглэлийн дагуу 1 оюутны тухайн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг үйл ажиллагааны зардлын болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тухайн жилийн инфляцийн түвшинтэй уялдуулан, эрх бүхий байгууллагаас гаргасан аргачлал, зөвлөмжийн дагуу тооцоолж жил бүр шинэчилдэг” байна. /Мандах бүртгэл” дээд сургуулийн цахим хуудаснаас авсан мэдээлэлд үндэслэв. БСШУЯ-наас холбогдох аргачлал болон журмыг ирүүлээгүй болно/*

Их, дээд сургуулиуд сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо 1 оюутны тухайн жилд сонгосон кредит цагаар тооцож харилцан адилгүй тогтоодог байна. Сургалтын төлбөрийн 1 кредитийн үнэлгээг шинэчлэн тогтоохдоо сургуулийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үндэслэдэг бөгөөд багш нарын цалин, хичээлийн практикийн зардал, судалгаа шинжилгээний ажил зэрэг сургалттай холбоотой зардал, оюутны үйлчилгээний зардал, шууд бус зардал зэрэг олон асуудлыг харгалзан үздэг байна.

Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тухайн сургуулийн зөвлөл хэлэлцэн тогтоодог бөгөөд үүнд яамнаас оролцох хууль эрх зүйн боломж байдаггүй байна. Зөвхөн 1 сурагчид оногдох хувьсах зардлын нормативт санхүүжилтийг тооцож олгохдоо сургалтын төлбөрийн хэмжээг харгалзан тодорхой хувиар олгох шийдвэрийг яамнаас гаргуулсан байна. /БСШУЯ-наас ирүүлсэн мэдээлэл/

БСШУ-ны сайдын 2003 оны 158 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд кредит цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэх журам”-ыг 2014 онд “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам” болгон шинэчлэн баталсан.

ШУТИС-ийн “Кредит систем” сургалтын гарын авлагад зааснаар “Кредит цагийн үндсэн нэгж нь тухайн улирлын туршид нэг 7 хоногт танхимд нэг цагаар орох лекцийн агуулга, түүнийг багшийн удирдлагын дор бүрэн эзэмшихэд зориулагдсан семинар, бие даасан ажил, лабораторийн болон дадлагын хичээлүүдийг агуулсан үйл



ажиллагааны нийлбэр цогц юм". Өөрөөр хэлбэл:

Кредит цаг нь:

- бакалаврын боловсрол ба кредит цаг
- оюутны хичээлийн агуулгыг эзэмшихэд зарцуулсан хөдөлмөрийн үнэлгээ
- оюутан суралцсан хичээлүүдийн агуулгыг эзэмшсэнийг илтгэх чанарын үнэлгээ, үнэлгээний голч дүнгийн тооцоо
- оюутны улирал, жилийн сургалтын төлбөр
- багшийн хөдөлмөрийн үнэлгээ гэсэн 5 зүйлд агуулагдсан үйл ажиллагааны нийлбэр цогц юм.

Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн 2014 оноос хойшхи сургалтын төлбөрийн 1 кредит цагийн дундаж үнэлгээ, өсөлт, бууралт зэрэг мэдээллийг сургууль тус бүрээр нь гаргасан мэдээллийг хавсралт 1-ээс үзнэ үү. 2014 оноос хойш төрийн өмчийн их дээд сургууль, коллежийн бакалаврын сургалтын төлбөр дунджаар 15.2%-иар нэмэгджээ.

**Хоёр. Гадаадын зарим орнуудын ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөр тогтоох, сургалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин**

**2.1 АНУ**

**Бүх шатны боловсролын тогтолцоо, онцлог**

АНУ-д Холбооны улсын муж бүхэн өөр өөрийн эрх зүйн зохицуулалт, боловсролын тогтолцоотой байна. Ийм учраас ерөнхий болон дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, удирдах, үйл ажиллагааг нь зохицуулах үйл ажиллагааг тухайн муж улсын эрх зүйн актаар зохицуулдаг. Нийтлэг зохицуулалтаас үзвэл, сургалтын байгууллагуудад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг муж улс нь олгодог боловч тэдгээрийг магадлан итгэмжилж, сургалтын чанарыг нь баталгаажуулдаггүй. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хувийн, ашгийн бус байгууллагууд гүйцэтгэдэг байна.

**АНУ-ын боловсролын системийн тогтолцоо<sup>3</sup>**

Тусгай зэрэг олгодоггүй докторын буюу ахисан төвшний мэргэжлийн зэрэг	Докторын сургалтын дараах судалгаа		
	Мэргэжлийн сургуулиуд /2-4 жил/	Докторын сургалт /2 жил/	Докторын сургалт /4 жил/
Магистрын зэрэг		Магистрын сургалт /2 жил/	
Бакалаврын зэрэг	Их сургуулийн сургалт /4 жил/		
Дээд боловсролын диплом буюу гэрчилгээ	Техникийн болон мэргэжлийн сургууль /2 жил/	Олон нийтийн коллеж /2 жил/	Холимог дунд сургууль /ахлах болон дунд анги/

3 Education chart, <http://pharmawiki.in/education-system/>

18 17 16 15	4 жилийн ахлах сургууль /9-12/	Дээд түвшний ахлах сургууль /10-12 анги/	
14 13 12 11 10 9		Завсрын ангиуд /7-9 анги/	
8 7 6	Бага сургууль		
5 4	Цэцэрлэг		
3 нас	Хүүхдийн ясли		

### **Бүх шатны боловсролын хяналт, санхүүжилт**

АНУ-ын муж бүхнээс улсын хэмжээний боловсролын нэгдсэн систем бүрдэх ба боловсролын салбарын хяналт, санхүүжилтийн асуудлыг холбооны улсын, мужийн, орон нутгийн гэсэн 3 түвшинд шийдвэрлэдэг байна.

Ерөнхий боловсролын систем нь дунд болон ахлах сургуулиас бүрддэг. Энэ шатны сургуулиуд нь орон нутгаас сонгогдсон удирдлагатай байдаг боловч сургалтын агуулга, боловсролын стандарт, шалгуурыг Холбооны Засгийн газраас хянаж, нэг стандарттай байхыг шаарддаг.

Холбооны улсын түвшинд, цэргийн академиудыг холбооны улсын төсвөөс бүрэн санхүүжүүлдэг ба зарим сургуулиудад төрөөс дэмжлэг үзүүлж болдог байна. АНУ-ын Боловсролын яамнаас америкийн засаг захиргааны муж улсуудын боловсролын хөтөлбөрийг удирдлага, санхүүжилтээр хангаж, эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, улсын хэмжээнд мэдээлэл цуглуулах, зөвлөгөө өгөх, боловсролын зарим хөтөлбөрт санхүүгийн тусламж үзүүлэх үүрэгтэй ажиллана.

Муж Улсын Үндсэн хуулиар, тухайн сургуулийн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн зөвлөлийн зүгээс хяналт тавьж ажиллахыг хуульчилсан. Муж улсын хотын болон тойргийн коллеж, их сургуулиуд нь тус тусын сургалтын үйл ажиллагааг явуулахтай холбоотой дүрэм, журмуудыг тогтоох эрхтэй.

### **Сургалтын төлбөр тооцох үндэслэл, чанарын үзүүлэлт**

Төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежуудын сургалтын төлбөрийн мэдээлэл, төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоож буй аргачлалын хувьд муж болгоны сургалтын үйл ажиллагаа явуулахтай холбогдсон дүрэм журмаар тогтоосон онцлог зохицуулалттай.

АНУ-ын Дээд боловсролын тухай хууль /1998 Amendments to the Higher Education Act /1965/ US Code title 20 Part C Cost of higher Education<sup>4</sup>/-ийн “Дээд боловсролын

4 1998 Amendments to the Higher Education Act,

зардал” бүлэгт АНУ-ын Боловсролын яамны харьяа Боловсролын Статистикийн Үндэсний төв /National centre for Education Statistics/ нь холбооны улсын түвшинд дээд боловсролын байгууллагуудын зардал, сургалтын төлбөртэй холбогдох үндэсний хэмжээний аргачлал боловсруулах чиг үүрэгтэй.

Боловсролын Статистикийн Үндэсний төв нь оюутны сургалтын төлбөр, хураамжийн жишиг стандартыг боловсруулна. Комиссар нь Боловсролын байгууллагын сургалтын төлбөр, хураамжийн стандартыг тодорхойлохдоо дараах судалгаанд үндэслэнэ.

- Хэрэглээний үнийн индекс, инфляци болон бусад холбогдох хүчин зүйлсийн харьцуулалт
- багш нарын цалин, тэтгэмж,
- захиргааны ажилтнуудын цалин, тэтгэмж, зардал;
- академик сургалтанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ;
- судалгаа шинжилгээ;
- үйл ажиллагааны болон засварын зардал, барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой зардал

Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр тогтоохдоо мэргэжлийн байгууллагаас жил бүр гаргадаг боловсролын үнийн индекс /Higher Education Price index/-ийг харгалзан тооцох аргачлалыг боловсруулсан. Тус улсад боловсролын байгууллагуудын магадлан итгэмжлэлийг магадлан итгэмжлэх эрх бүхий төрийн бус байгууллагууд хэрэгжүүлэх ба коллеж, их сургуулиудын дээд боловсролын хөтөлбөрийн чанар, сайжруулж буй байдалд хяналт, шалгалт хийнэ.

### Оюутнуудад үзүүлдэг тусламж, дэмжлэгүүд

1965 оны АНУ-ын “Дээд Боловсролын Тухай хууль” (*Higher Education Act, Title IV- Student Assistance*), 2008 оны Их, Дээд Боловсролын Боломжийн тухай (*Higher Education Opportunity Act, Title IV- Student Assistance*) зэрэг хууль тогтоомжоор зохицуулсан байна.

Холбооны Засгийн газрын Оюутны Тусламжийн (*Student Aid*) гол зорилго нь **буцалтгүй тусламж (grant)** болон **зээлд (loan)** хамрагдах болзлыг хангаж буй бүх оюутнуудыг эдгээр санхүүгийн тусламж дэмжлэгт (*Aid*) хамруулах явдал юм. Эдгээр хөтөлбөрүүдээр дамжуулан АНУ-ын засгийн газраас жил бүр 83 тэрбум гаруй долларын зээл болон буцалтгүй тусламжийг 14 сая их дээд сургуульд суралцагсад олгож байна.

Нэгдсэн Улсын Боловсролын Газрын харьяа Холбооны Засгийн газрын Оюутны Тусламжийн газраас (*Federal Student Aid*) оюутнуудад олгож байгаа дэмжлэгийг буцалтгүй тусламж (*grants*), ажиллаж-сурах болон зээл хэмээн 3 ангилж дэмжлэг үзүүлдэг байна.

### АНУ-ын Засгийн газраас оюутнуудад үзүүлдэг тусламж дэмжлэгүүд

Зээл тусламж	Хэлбэр	Эрх зүйн акт	Хэнд	Хэмжээ (жилд)
--------------	--------	--------------	------	---------------

<b>Холбооны засгийн газрын Пеллийн тэтгэлэг (Сенатч Клейборн Пеллийн нэрэмжит)</b>	<b>Буцалтгүй тусламж (grant)</b>	Higher Education Act 1965, Title IV, Subpart 1, Sec.401 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.401	Бакалаврын оюутнуудад зориулсан. Хүсэлт гаргасан оюутнуудын санхүүгийн хэрэгцээг харгалзан олгоно.	2008–09: \$400–\$4,731
<b>Холбооны ЗГ-ын боловсролын нэмэлт тэтгэлэг (FSEOG)</b>	<b>Буцалтгүй тусламж (grant)</b>	Higher Education Act 1965, Title IV, Subpart 3 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.406	Санхүүгийн онцгой хэрэгцээ бүхий оюутнуудад зориулсан. Пеллийн тэтгэлэгт хамрагдагсад давуу эрхтэй байна. Уг тэтгэлгийг тухайн сургуулийн санхүүгийн боломжийг харгалзан олгоно.	\$100–\$4,000
<b>Сургалт судалгааны өрсөлдөх чадварын тэтгэлэг (ACG)</b>	<b>Буцалтгүй тусламж (grant)</b>	Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.402	Пелл тэтгэлэгт хамрагдах боломж бүхий, мэргэжлийн сертификат олгох хөтөлбөрийн 1 болон 2 дугаар дамжаанд эсвэл зэрэг олгох хөтөлбөрийн 1 дүгээр дамжаанд суралцаж байгаа, хамгийн багадаа <a href="#">half-time</a> сургалтанд хамрагдагсад.	
			2-р дамжаа: ахлах сургуулийн чанд хатуу сургалтанд хамрагдсан, 2005 оны 1 сарын 1-нээс хойш төгссөн, их дээд сургуулийн 1-р дамжаагаа хамгийн багадаа 3 голч дүнтэй дүүргэсэн.	2-р дамжаа: \$1,300 хүртэл
<b>Шинжлэх ухаан, математикийн үндэсний тэтгэлэг (National SMART Grant)</b>	<b>Буцалтгүй тусламж (grant)</b>		Пеллийн тэтгэлэгт хамрагдах боломжтой их дээд сургуулийн 3, 4 (5 жилийн хөтөлбөр бол 5) –р дамжаанд хамгийн багадаа <a href="#">half-time</a> суралцдаг оюутнууд. Дүнгийн голч нь 3-аас дээш байх.	Жилд \$4,000 хүртэл

<p><b>Коллеж болон Их дээд сургуулиудад Багшийн мэргэжлээр сурч буй оюутнуудад үзүүлэх тэтгэлэг (TEACH) Grant</b></p>	<p><b>Нөхцөлтэй буцалтгүй тусламж (grant):</b> Тус үйлчилгээний үүрэг шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тэтгэлэг олгогдсон өдрөөс эхлэн хүүг нөхөн тооцож, үндсэн мөнгөн дүнгийн хамт төлнө.</p>	<p>Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.412</p>	<p>Бага болон дунд сургуулийн багш болохоор Бакалавр болон магистр докторын зэргээр сурч байгаа болон сурах гэж байгаа “Алба хаах гэрээ”-нд гарын үсэг зурсан оюутнууд. Тус гэрээнд гарын үсэг зурснаар тухайн оюутан нь сургуулиа төгссөнийхөө дараа 8 жилийн дотор шаардлагатай байгаа салбарт бага болон дунд сургуульд бүтэн 4 жил ажиллахыг зөвшөөрнө.</p>	<p>Жилд \$4,000 хүртэл</p>
<p><b>Холбооны ЗГ-ын ажиллах-сурах хөтөлбөр</b></p>	<p>Сургуульд сурч байх хугацаандаа ажиллаж олсон мөнгө буцаж төлөгдөхгүй.</p>	<p>Higher Education Act 1965, Title IV, Sec.441 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.441</p>	<p>Бакалавр болон Магистр докторын оюутнууд сургууль болон сургуулиас гадуур ажиллах боломжтой бөгөөд хамгийн багадаа цалингийн доод хэмжээгээр цалинжина.</p>	<p>Тогтсон хэмжээ байхгүй.</p>
<p><b>Федерал Перкинзийн зээл</b></p>	<p>Зээл: эргэн төлөгдөнө</p>	<p>Higher Education Act 1965, Title IV, Sec.461 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.461</p>	<p>Бакалавр болон магистр докторын оюутнуудад зориулсан. Зээл олгосон сургуульдаа эргэн төлнө. 5 хувийн хүүтэй</p>	<p>Бакалаврын сургалт: \$5,500 хүртэл; магистр доктор боон мэргэжлийн зэрэг: \$8,000 хүртэл</p>
<p><b>Дэмжлэгтэй Стаффордын зээл</b></p>	<p>Зээл: эргэн төлөгдөнө</p>		<p>Дэмжлэгтэй Стаффордын зээлийн хүүг Нэгдсэн Улсын Боловсролын Газар хариуцаж төлөх бөгөөд уг зээлийг хүлээн авагч нь санхүүгийн хэрэгцээгээ баталж үзүүлэх шаардлагатай. Хамгийн багадаа <a href="#">half-time</a> –р их дээд сургуулийн сургалтад хамрагдах ёстой. 6 хувийн хүүтэй.</p>	<p>Дүнгийн байдлыг харгалзан \$3,500–\$8,500 байна.</p>

<b>Дэмжлэггүй Стаффордын зээл</b>	Зээл: эргэн төлөгдөнө	Higher Education Act 1965, Title IV, Sec.4286H	Дэмжлэггүй Стаффордын зээлийн хүүг зээлдэгч өөрөө төлөх бөгөөд санхүүгийн хэрэгцээгээ заавал батлан үзүүлэх шаардлагагүй. Хамгийн багадаа <a href="#">half-time</a> –р их дээд сургуулийн сургалтад хамрагдах ёстой. 6,8 хувийн хүүтэй.	дүнгийн байдал болон гэр бүлийн хараат хүмүүс бий эсэхийг харгалзан \$5,500–\$20,500
<b>ПЛАС зээл</b>	Зээл: эргэн төлөгдөнө	Higher Education Act 1965, Title IV, Sec.428.B Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.461	Их дээд сургуулийн бакалавр болон магистр, докторын сургалтанд хамгийн багадаа <a href="#">half-time</a> хамрагддаг, эцэг эхээсээ хараат байдаг оюутнуудын эцэг эхэд зориулсан зээл. Санхүүгийн хэрэгцээг батлах шаардлагагүй. Зээлдэгч нь урьд өмнө ямар нэгэн зээл авч байсан бол зээлийн зөрчилгүй байх. ПЛАС зээл нь дэмжлэггүй зээл бөгөөд зээлдэгч нь бүх хүүг төлнө. 8,5 хувийн хүүтэй.	Дээд хэмжээ нь тухайн сургуульд суралцахад шаардлагатай, сургалт, ном, байр хоол гэх мэт бүх зардлаас оюутны авч буй бусад санхүүгийн тусламжийг хассантай тэнцүү байна. Доод хязгаар байхгүй.

Дээрх зээл тусламжид хамрагдахад дараах үндсэн шалгууруудыг харгалзана.  
Үүнд:

- Санхүүгийн хэрэгцээ шаардлагаа баталж үзүүлэх (*дээр хүснэгтэд дурдсан тодорхой зээлүүдээс бусад*),

Нэгдсэн Улсын иргэн байх. Хүчинтэй Нийгмийн хамгааллын дугаар бүхий байнгын оршин суугч, цагаач, дүрвэгч, зэрэг АНУ-ын харъяат бус хүмүүс,

- Их дээд сургуулийн ямар нэгэн зэрэг, сертификатын хөтөлбөрт хамрагдах,
- Их дээд сургуулийн боловсролд хамрагдах боломжтой болохоо доорх хэлбэрүүдийн аль нэгээр батлах
  - Дунд сургууль төгссөн гэрчилгээ эсвэл Ерөнхий Боловсролын Хөгжлийн Сертификат
  - Дунд сургуулийн диплом эсвэл ЕБХС байхгүй бол тухайн сургуульд элсэн суралцах чадвартай эсэхийг шалгах шалгалтад тэнцсэн байдал
  - Холбооны Засгийн газрын зүгээс хүлээн зөвшөөрсөн тухайн муж улсын бусад стандартуудыг хангасан эсэх
  - Мужийн хуулийн дагуу гэрээр дунд сургуулийн боловсрол эзэмшсэн
  - Их, дээд сургуульд элсэн орсныхоо дараа шаардлагатай сурлагын түвшинг хангаж чадах.

## 2.2. Австрали улс

Австрали улсын боловсролын чанар, стандарт нь дэлхийд дээгүүрт ордог бөгөөд улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн нэг нь боловсролын салбар юм. Тус улс нь бүх

шатны боловсролыг жигд, хүртээмжтэй, чанартай олгох зорилгоор бүх шатны боловсролд нэгдсэн стандартыг хэрэгжүүлж даяарчлагдсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, хөрвөх чадвар бүхий боловсон хүчин бэлтгэхэд төрийн бодлогоо чиглүүлэн ажилладаг.

Австрали улсын засгийн газраас бага, дунд сургуулийн сурагчдыг даяарчлагдсан нийгэмд хөдөлмөр эрхлэх чадвартай мэдлэг олгох зорилгоор 2008 онд “Боловсролын шинэчлэлийн хөтөлбөр”-ийг баталж, энэхүү хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас бага, дунд сургуулиудтай гэрээ байгуулж ажилласан нь үр дүнгээ өгч бага, дунд боловсролын чанараараа дэлхийн хэмжээнд тэргүүлэх болсон байна.

Өнөөгийн байдлаар тус улсын их, дээд сургуулиудаас 11 нь дэлхийн шилдэг 100-н сургуулийн жагсаалтад багтдаг.

### **Австралийн дээд боловсролын чанар, стандартын агентлаг<sup>5</sup>** **/TEQSA/**

Дээд боловсролын чанар, стандартын агентлаг нь Австралийн хувийн болон улсын дээд сургуулиудын боловсролын босго стандарт, чанарыг баталж мөрдүүлэх, оюутнуудын эрх ашгийг хамгаалах үүрэгтэй ажилладаг бие даасан агентлаг бөгөөд үйл ажиллагаа болон гаргасан шийдвэр, зохицуулалтынхаа талаар олон нийтэд ил тод мэдээлэх, тайлагнах үүрэгтэй байдаг. Агентлагийн шийдвэр, зохицуулалтын хэрэгжилтэнд олон нийтийн нөлөөлөл чухал үүрэгтэй байдаг. Улсын болон хувийн их, дээд сургуулиуд нь Дээд боловсролын чанар, стандартын агентлагт бүртгүүлж, 7 жил тутамд магадлан итгэмжлэл хийлгэдэг. Мөн **дээд боловсролын чанар, стандартын агентлагын харьяа** хилийн чанадад суралцаж байгаа оюутнуудын эрх ашгийг хамгаалах, боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллага /ESOS-Education Services for Overseas Students/<sup>6</sup> нь гадаадад суралцаж буй оюутнууддаа боловсролын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ үзүүлж, эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлдэг.

Дээд боловсролын чанар, стандартын агентлагийн үйл ажиллагаа, эрх, үүргийг “Дээд боловсролын чанар стандартын агентлагийн тухай хууль”<sup>7</sup>/2011/-аар зохицуулдаг.

### **Бүх шатны сургуулийн санхүүжилт, сургалтын төлбөр тогтоох үндэслэл<sup>8</sup>**

Австрали улсын бүх шатны сургуульд улсын болон орон нутгийн санхүүжилт олгодог бөгөөд хувийн болон улсын сургуулийн санхүүжилт харилцан адилгүй байна. Энэхүү санхүүжилтийг Австралийн Боловсролын тухай хууль /2013/<sup>9</sup>-д заасан аргачлалыг үндэслэн олгодог. Улсын мэдлийн бага, дунд сургууль нь тухайн улсын иргэнд үнэ төлбөргүй байдаг бөгөөд улс болон орон нутгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг.

Тус хуулийн 3, 4 дүгээр бүлэгт зааснаар дараах үзүүлэлтүүдийг томьёолж тухайн сургуульд хуваарилах санхүүжилтийн хэмжээг тодорхойлдог байна.

Үүнд: Үндсэн үзүүлэлт болох тухайн сургуульд нэг жилд суралцах сурагчийн тоо, нэг сурагчид ноогдох хуулиар тогтоосон санхүүжилтийн хэмжээ, тухайн

5 TEQSA, <http://www.teqsa.gov.au>

6 Education Services for Overseas Students , <http://www.esos.curtin.edu.au>

7 Tertiary Education Quality and Standards Agency Act /2011/,  
<https://www.legislation.gov.au/Details/C2015C00622>

8 Department Of Education and Training, <https://www.education.gov.au/>

9 Higher Education Act /2013/, <https://www.legislation.gov.au/Details/C2013A00067>

сургуульд үзүүлж буй олон нийтийн санхүүгийн дэмжлэг, бусад үзүүлэлт болох хөгжлийн бэрхшээлтэй сурагчид, уугуул болон торрес арлын сурагчид, амьжиргааны түвшин доогуур сурагч, төрөлжсөн биш энгийн сургууль, бага хүчин чадалтай сургууль зэргийг харгалзан тогтооно.

Энэхүү хуулийн ач холбогдол нь тухайн сургуулийн хэрэгцээнд тохирсон санхүүжилт олгодог болсон, сургалтын чанар, санхүүжилтийг нээлттэй ил тод, ойлгомжтой байх нөхцлийг бүрдүүлж өгсөн байна.

Австрали улсын их дээд сургуулиуд нь Дээд боловсролыг дэмжих тухай хууль /2003/ хуулийн дагуу жил бүр сургалтын төлбөрөө тогтоодог. Сургалтын төлбөрийг их дээд сургуулийн зөвлөл тогтоох эрхтэй бөгөөд сургалтын зардал, стратеги төлөвлөгөө, зах зээлийн эрэлт хэрэгцээний чиг хандлага, үйлчилгээний эрэлт хэрэгцээ, зардлын өсөлтийн таамаг, улсаас тавьсан хязгаарлалт, шаардлагатай холбоотой эрх зүйн баримт бичиг зэргийг үндэслэн дараах зарчмыг баримтлан сургалтын төлбөрөө тогтоодог. Үүнд:

- Сургуулийн стратеги төлөвлөгөө, санхүүгийн бодлоготой уялдсан байх,
- Газар нутгийн байршил, сургалтын онцлог, сургалтын төрлийг харгалзан үзэх,
- Хууль, тогтоомж, бодлого журамтай нийцсэн байх,
- Төлбөрийн тухай мэдээлэл олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх,
- Сургалтын төлбөрийн буцаан олголт, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлтийг *улсын болон сургуулийн хууль тогтоомжид нийцүүлсэн байх*,

### **Төрөөс их, дээд сургуулийн оюутанд үзүүлдэг санхүүгийн дэмжлэг<sup>10</sup>**

Дээд боловсролыг дэмжих тухай хууль /2003/ хуулиар төрөөс их, дээд сургуулийн оюутанд үзүүлдэг санхүүгийн дэмжлэгүүдийн хэлбэр

#### ***Хамтын нөхөрлөлийн орнуудын дэмжлэгийн газар /Common Wealth Supported Place/***

Хамтын нөхөрлөлийн орнуудын дэмжлэгийн газар нь дээд боловсрол эзэмших оролцоог нэмэгдүүлж, дэмжих зорилготой. Австралийн засгийн газар нь CSP санхүүжүүлэн дэмждэг бөгөөд, төлбөрийн хэсгийг шууд тухайн сургуульд нь төлдөг. Дэмжлэг нь зээл биш бөгөөд оюутнууд дэмжлэгийн мөнгийг буцааж төлөх шаардлагагүй. Гэхдээ оюутнууд өөрийн сурч буй чиглэлээс хамааран оюутны оролцооны хувь болох төлбөрийн үлдэгдэлийг өөрөө төлөх ёстой ба энэхүү төлбөрийн хэмжээг Австралийн засгийн газраас тогтооно.

#### **Дээд боловсрол олгох зээлийн хөтөлбөр /Higher Education Loan Programme/**

Дээд боловсрол олгох зээлийн хөтөлбөр нь оюутнуудын сургалтын төлбөрийг төлөхөд туслах зорилготой, хүү бодогдохгүй. Хаана суралцах, тухайн оюутны санхүүгийн байдал зэргээс шалтгаалан энэхүү хөтөлбөр нь 5-н төрлийн зээлээс бүрддэг.

- **HECS-HELP-** Оюутны зээл болон хөнгөлөлт. Оюутны оролцооны хувь болох төлбөрийг төлөх, эсвэл \$500 болон түүнээс дээш дүнтэй урьдчилгаа төлбөр төлсөн оюутнуудад 10%-ийн хөнгөлөлт олгох.
- **FEE-HELP-** Оюутны сургалтын төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн төлөхөд тусалдаг. Энэхүү зээлийг байр, орон сууц болон сурах бичиг худалдан авах зэрэгт ашиглаж болохгүй.

---

10 Higher education support act 2003, [www.studyassist.gov.au](http://www.studyassist.gov.au)



- **VET-FEE-HELP-** Илүү өндөр түвшний мэргэжлийн боловсрол, сургалтанд хамрагдаж өндөр ур чадвар олж авахад туслах. Шалгуур нь, мэргэжлийн дипломын зэрэг болон түүнээс дээш. Зөвхөн сургалтын төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн төлөхөд зориулагдах ба байр орон сууц болон сурах бичиг зэргийн зардал багтахгүй.
- **SA-HELP-** Оюутны сургалтын төлбөр болон бусад хэрэгцээний зардлыг бүхэлд нь болон хэсэгчлэн төлөхөд тусалдаг.
- **OS-HELP Loan-** Зөвхөн хамтын нөхөрлөлийн оронд суралцах тохиолдолд олгогдох бөгөөд олгогдох дүн нь байр орон сууц, нислэгийн зардлаас хамаарна. Оюутнууд суралцах хугацаандаа 2 удаа энэхүү зээлийг авах боломжтой.

### **Оюутны орлогын дэмжлэг /Student Income Support/**

Хүмүүнлэгийн үйлчилгээний газраас хэрэгжүүлдэг бүтэн болон хагас цагаар суралцдаг оюутнууд, Австралийн дадлагажигч оюутан нарт олгох боломжтой дэмжлэг байдаг. Үүнд :

- **Youth Allowance-** Австралийн 16-24 насны бүрэн цагаар суралцдаг оюутан болон Австралийн дадлагажигч нарт олгогддог сургалтын төлбөрийн дэмжлэг,
- **Austudy-** 25 болон түүнээс дээш насны бүрэн цагаар суралцдаг болон Австралийн дадлагажигч нарт олгогддог дэмжлэг,
- **AUBSTUDY-** Австралийн Уугуул болон Торрес арлын 16 болон түүнээс дээш насны оюутнуудад олгодог амжиргааны болон бусад нэмэлт дэмжлэг,

### **Хүүхэд асрах тэтгэмж /Child care assistance/**

Мөн Австралийн засгийн газраас “Хүүхэд Асрах Тэтгэмж болон Хүүхэд Асрах Хөнгөлөлт”-өөс батлагдсан хүүхэд асрахад гарах зардлыг олгох санхүүгийн тусламжийг гэр бүлд үзүүлдэг.

### **Тэтгэлэг /Scholarship/**

Бакалавр, магистр, докторын түвшинд болон судалгааны олон салбарт олгогддог нилээдгүй олон төрлийн тэтгэлэг байдаг. Эдгээр нь Австралийн болон олон улсын оюутнуудын аль, алинд нь олгогдох боломжтой тэтгэлэг юм.

## **2.3 Их Британи**

Их Британи улсын боловсролын салбарын үйл ажиллагааг “Боловсролын тухай хууль” (Education Act 2011), “Дээд боловсролын тухай” (Higher Education Act 2004), “Академийн тухай хууль 2010” (Academies Act 2010), “Хүүхдийн суралцах болон ур чадварын дадал, чадвар олгох тухай хууль” 2009, (The Apprenticeships, skills, children and learning Act 2009), “Боловсрол ба хяналт шалгалтын тухай хууль” 2009 (The Education and Inspections Act 2009), “Дээд боловсролын тухай хууль ба нэмэлт” 1992 (The Further and Higher Education Act 1992) зэрэг хуулиудаар зохицуулж байна.

Их Британид их, дээд сургуулийн сургалтын чанарыг Засгийн газрын Дээд боловсролын Чанарын Баталгааны Аентлаг (*Quality Assurance Agency for Higher Education*—QAAHE) хариуцан ажиллах ба их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх, оюутнуудад дэмжлэг үзүүлэх болон сургалтын орчин, чадавхи хэр зэрэг байгаад үнэлгээ өгч, тодорхой шалгуур үзүүлтүүдээр дүгнэдэг байна.

ИБУИНВУ-д 2015 оны 12 сард гаргасан судалгаагаар төрийн өмчийн болон хувийн

хэвшлийн 130 их дээд сургууль, коллеж байдаг ба үүнээс 106 нь Англид байдаг байна.

### **Английн Дээд Боловсролын Санхүүжилтийн Зөвлөл** (*Higher Education Funding Council for England–HEFCE*)

Английн Дээд Боловсролын Санхүүжилтийн Зөвлөл нь их дээд сургуулиудын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсролын байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх болон өндөр чанартай боловсрол олгох, судалгаа болон холбогдох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой. 2015-2016 онд тус зөвлөл нь Английн их, дээд сургууль коллежид Их Британиийн Засгийн газраас олгосон 3,97 тэрбум фунт стерлинг хуваарилжээ. Энэхүү санхүүжилтийг их, дээд боловсролын бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх, сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх, оюутнуудад тэтгэлэг болон зээл олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх зэрэгт зарцуулжээ. Мөн их, дээд сургуулиудад багшлах боловсон хүчин бэлтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны төслийг санхүүжүүлэх, боловсролын байгууллага болон олон нийтийн уялдаа холбоог бий болгох, салбарын манлайлал, засаглал, менежментийг сайжруулах, оюутны сэтгэл ханамжийн үнэлгээнд суурилсан тогтолцоог бий болгоход анхаарсан.

Их Британид төрөөс оюутнуудад үзүүлэх дэмжлэгийг “Английн дээд боловсролын санхүүжилтийн зөвлөл” (*Higher Education Funding Council for England*), Английн оюутны санхүүжилтийн газар /Student Finance England/ зэрэг бие даасан байгууллагууд хариуцдаг.

“Боловсролын тухай хууль”-ийн 9-р бүлгийн 76-77 зүйлд оюутны сургалтын төлбөр, зээл, төлбөрийн хөнгөлөлт, сургалттай холбоотой асуудлыг Английн боловсролын салбарын Төрийн нарийн бичгийн дарга, Уэльстэй холбоотой асуудлыг Уэльсийн боловсролын сайд хариуцахаар заасан байдаг.

“Дээд боловсролын тухай” хуулийн 3-р бүлгийн 23 зүйлд зааснаар оюутны төлбөрийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлахаар хуульчилсан, ингэхдээ Английн Дээд боловсролын санхүүгийн зөвлөл, сургуулийн дэргэдэх Хөгжлийн агентлагын зөвлөлүүдийн шийдвэрийг харгалзан үзэж (*өөрөөр хэлбэл оюутны санхүүжилтын газар*) оюутны төлбөр, гэрээний нөхцөл, тэтгэлэг, зээлийн асуудлуудыг шийднэ гэж заажээ.

Мөн хуулийн 3-р бүлгийн 24 зүйлд зааснаар Английн дээд боловсролын санхүүжилтийн зөвлөлөөс сургалтын төлбөрийг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан тухайн жилийн академик болон курсээр олгох сургалтын хөтөлбөрийн батлагдсан агуулгад нийцүүлэх, төлбөрийг төлөвлөгөөнд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх зэрэг заалтуудыг мөрддөг байна.

Англи, Уэльс, Умард Ирланд нь төрөөс санхүүжилт олгох их, дээд сургуулиудын боловсролын чанарыг үнэлэх зорилгоор **Дээд боловсролын чанарын үнэлгээний шинэчилсэн загвар**<sup>11</sup> хэмээх баримт бичгийг гаргажээ. 2016-2018 онд энэхүү чанарын үнэлгээний загварыг туршилтын журмаар Англи, Уэльс, Умард Ирланд, Шотландад хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Чанарын үнэлгээний шинэчилсэн загвар нь Европын стандарт, аргачлал, зааврын дагуу илүү нарийвчилсан түвшинд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны

11 <http://www.hefce.ac.uk/pubs/year/2016/201603/>

чанарыг үнэлэх зорилготой. Ингэснээр сургалтын байгууллагуудын засаглал, удирдлага, санхүүжилтийн хэлбэрийг сайжруулах, санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бий болгох, сургалтын байгууллагуудыг төлөвшүүлэх, хамтын засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, дээд боловсролын стратеги төлөвлөгөө, бодлогын орчинг сайжруулах, иргэдэд тэгш хүртээмжтэй дээд боловсрол олгох зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэхээр төлөвлөсөн байна. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх явцад ИБУИВУ-ын хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрсөн чанарын үнэлгээний системийг боловсруулан төлөвшүүлэх нь чухал ач холбогдолтой хэмээн үзсэн байна.

## Оюутны дэмжлэг тусламж

Английн Засгийн газраас Английн оюутны санхүүгийн байгууллагаар дамжуулан тэтгэмж *grant*, зээл *loan*, сургуулиас нь олгодог тэтгэлэг *bursary* зэрэг хэлбэрүүдээр оюутнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг бөгөөд оюутан хэрэгцээтэй үедээ санхүүгийн дэмжлэг авах ба энэ мэт авсан зээлээ сургууль төгсөх хүртлээ буюу жилд £ 15000 фунт стерлинг орлого олдог болох хүртлээ эргүүлэн төлөхгүй байж болно.

Дээрх хууль тогтоомжид заасны дагуу Англи Улсын Засгийн газраас их дээд сургуулийн оюутнуудад зориулан дараахь төрлийн дэмжлэг тусламцааг үзүүлдэг. Үүнд:

1. **Буцалтгүй тусламж, тэтгэлэг** *Grant*
2. **Зээл** *Loan*/ гэсэн үндсэн хоёр төрлийн дэмжлэг хамаарна.

### 1. Буцалтгүй тусламж, тэтгэлэг

- **Эргэн төлөгдөх нөхцөлгүй амьжиргааны тэтгэлэг:**

Энэ нь сар тутам тогтоосон хэмжээгээр тогтмол олгодог тэтгэлэг юм. “Боловсролын тухай” болон “Дээд боловсролын тухай” хуулиудад зааснаар жилийн £25000-аас доош орлого бүхий айлын хүүхдүүд £ 2906 хүртэл тэтгэмж авах эрхтэй. Харин жилийн £ 50020 хүртэл орлоготой айлын хүүхдүүд хэсэгчилсэн тэтгэлэг авдаг байна. Хэрэв шинээр их дээд сургуульд элсэн орж байгаа бол тухайн оюутнуудын 40% нь бүрэн амьжиргааны тэтгэлэгт хамрагдах боломжтой байдаг байна. *Бүрэн амьжиргааны тэтгэлэг нь оюутны суралцахад шаардагдах бүхий л амьжиргааны зардлыг санхүүжүүлэхийг хэлнэ/*

- **Хүүхэдтэй болон тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг:**

Энэ нь суралцахыг хүсэж байгаа бөгөөд тэднээс хамааралтай асрамжлах шаардлагатай хүмүүстэй хамт амьдардаг тохиолдолд төрөөс тэдгээр оюутнуудад үзүүлдэг нэмэлт амьжиргааны тэтгэлгийг хэлнэ. Энэ төрлийн тэтгэлэг нь дараахь хэлбэртэй байна.

Хүүхэдтэй болон бусад тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг	Дээд хэмжээ
<b>Хүүхэдтэй оюутны тэтгэлэг</b>	
-1 хүүхэдтэй бол	долоо хоногт £ 148,75
-2 хүүхэдтэй бол	долоо хоногт £255
<b>Эцэг эхийн сургалтын тэтгэмж</b>	жилд £ 1508

<b>Насанд хүрсэн тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг /насанд хүрсэн хүүхэд орохгүй/</b>	жилд £2642
--	------------

• **Тахир дутуу болон хөгжлийн бэрхшээлтэй оюутны тэтгэлэг:**

Мөн дээр дурьдсан хуулиудад зааснаар хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад доорх төрлийн тэтгэлгийг дараахь хувь хэмжээтэйгээр олгоно. Үүнд:

<b>Тусгай аппарат хэрэгслийн тэтгэмж</b>	<b>нэг курст £ 5161.</b>
<b>Эмнэлгийн бус тусламжийн тэтгэмж /бүтэн болон хагас өдрөөр сурч байгаатай холбогдон өөрчлөгдөнө./</b>	жилд £20520.
<b>Тахир дутуугийн тэтгэмж</b>	Жилд £ 1724
<b>Замын зардал:</b>	дээд хязгаар байхгүй.

**2. Зээл:**

• **Сургалтын төлбөрийн зээл:**

Английн Засгийн газраас дээд сургуулиудын оюутнуудын хувьд сургалтын төлбөрт нэмэрлэх зорилгоор олгодог сургалтын төлбөрийн зээл олгох харилцаа хуулиар зохицуулагдсан байх ба түүний хэмжээ нь £ 3290 хүртэл байна. Уг зээлийн хэмжээг оюутны ар гэрийн жилийн дундаж орлогыг харгалзан тогтоодог бөгөөд “Английн оюутны санхүүжилтийн газар” (*Student finance department of England*) тухайн сургууль руу шууд төлдөг байна.

Сургалтын төлбөрийн зээлд хамрагдахад тавигдах шаардлагууд:

- Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт бол
  - Оюутан, түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь хууль ёсоор дүрвэх болон тус улсад чөлөөтэй орж гарах зөвшөөрөл авсан бол
  - Оюутан болон түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь Европын Холбооны улсын харъяат бол
  - Оюутан тус улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан бол
- Хуульд заасан бусад шаардлагуудыг хангасан тохиолдолд Засгийн газрын зээлд хамрагдах эрхтэй болно.

Зээлийн эргэн төлөлт: Оюутны сургалтын зээлийг дараахь хэлбэрээр эргэн төлж болно. Үүнд:

- Зээлдэгч зээлээ шууд “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс”-т төлөх
- Татварын системээр дамжуулан төлөх
- Ажил олгогч цалингаас нь хасах хэлбэрээр гэсэн үндсэн 3 хэлбэрээр төлнө.

“Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс” нь Их Британийн Боловсролын яамны харъяа газар бөгөөд их, дээд сургууль төгсөгчдийн ажил, эрхлэлт, сургалт болон түүнтэй холбоотой бусад асуудлыг хариуцах ба нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

Гадаадын зээлдэгч нар нь 3 сараас илүү хугацаагаар Их Британиас гарах тохиолдолд

“Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс”-д мэдэгдэх үүрэгтэй бөгөөд сар бүрийн тогтсон өдөр төлбөрийн төлөвлөгөөний дагуу зээлийг эргэн төлнө. Хэрэв зээлдэгчийг тогтсон төлөвлөгөөний дагуу зээлээ тогтмол төлж байна гэж үзвэл “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс” нь орлогын дагуу төлөхийг зөвшөөрдөг. Зээлдэгч төлбөр хийх хугацаанаас хойш 12 сарын цалингийнхаа нийлбэрийн 9%-тай тэнцэх мөнгийг 12 хувааж төлнө.

- **Эргэн төлөгдөх нөхцөлтэй амьжиргааны зээл:**

Оюутны хоол байрны мөнгө, сургалтын материалын төлбөр зэрэг сургалтын бусад зардлыг төлөхөд зориулсан зээл юм. Уг зээлийн хэмжээ нь хаана сурч байгаа болон өөр эрх бүхий байгууллагаас амьжиргааны тэтгэлэг авсан эсэх, оюутны өөрийн болон ар гэрийн орлогын хэмжээнээс хамаарна. Эцэг эхээсээ хол Лондон хотод сурч байгаа бол жилийн £ 6928, эцэг эхээс хол, Лондонгоос бусад хотод сурч байгаа бол £ 4950, сурах хугацаандаа эцэг эхийн хамт амьдарч байгаа бол жилд £ 3838 гэх мэт харилцан адилгүй хэмжээтэй байна.

Дээрх тэтгэлэг болон зээлүүдэд хамрагдахад доорх ерөнхий болзлууд шаардагдана. Үүнд:

- Нэгдсэн Вант Улсын иргэн байх, эсвэл тогтмол суурьшилтай оршин суугч байх.
- Хэвийн оршин суугч байх.
- Их дээд сургуулийн сургалт эхлэхээс 3 жилийн өмнөөс эхлэн Нэгдсэн Вант Улс, Канадын арлууд болон Менийн аралд оршин суусан байх.
- Амьжиргааны зээлд хамрагдахад 60-аас доош настай байх, /харин Сургалтын төлбөрийн зээлд хамрагдахад насны дээд хязгаар байхгүй./
- Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт байх зэрэг ерөнхий шаардлагуудыг хангасан байх шаардлагатай.

## 2.4. БНСУ

Солонгос улсын боловсролын салбарын эрх зүйн харилцааг Суурь боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Цэцэрлэгийн боловсролын тухай хууль, Хувийн сургуулийн тухай хууль, Дээд боловсролын тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг. Тус улсын их, дээд сургуулиудын дийлэнх нь хувийн хэвшлийн сургуулиуд байдаг. /Нийт 171 их, дээд сургуулийн 145 нь буюу 85% нь хувийн хэвшлийн сургуулиуд байна./

Солонгосын боловсролын салбарын хяналтын чиг үүргийг Боловсрол, шинжлэх ухаан, технологийн яам өмчийн хэлбэр үл харгалзан хэрэгжүүлэх бөгөөд Дээд боловсролын тухай хууль<sup>12</sup> болон Хувийн сургуулийн тухай хууль, Их сургуулийн сургалтын төлбөрийг тогтоох журам<sup>13</sup>-д заасны дагуу сургалтын төлбөрийн жишгийг баталж өгдөг. Улсын сургуулиудын хувьд төсвөөс бүх санхүүжилтээ авдаг бол хувийн сургуулиудын хувьд санхүүжилтийн гол эх үүсвэр нь сургалтын төлбөр байдаг. Хувийн сургуулийн зардлын ердөө 3%-ийг төрөөс санхүүжүүлж байна.

Солонгос улсын Боловсрол, шинжлэх ухаан, технологийн яамны 2013 онд баталсан “Их сургуулийн сургалтын төлбөрийг тогтоох журам”-д заасны дагуу Сургалтын төлбөрийн хяналтын хороо ажилладаг. Сургалтын төлбөрийн хяналтын хороо нь сургууль тус бүр дээр Дээд боловсролын тухай хуульд заасны дагуу сургалтын болон бусад төлбөрийг тооцож гаргах чиг үүрэгтэй ажилладаг. Хяналтын хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба сургууль оюутан суралцагсад, төгсөгчдийн хороо болон эцэг, эхийн төлөөллийг оролцуулна.

Тус журмаар сургалтын төлбөрийг тооцохдоо Боловсролын тухай хуулийн 11.7-г удирдлага болгон өнгөрсөн жилийн дундаж сургалтын төлбөр дээр үндэслэн тухайн жилийн инфляцийн түвшин, зардлыг өсөлт, бууралтыг харгалзан бакалавр, магистр, докторын сургалт тус бүрээр тооцоолж гаргах ба салбарын сайд батална.

Хяналтын хорооны ажиллах хугацааг сургуулийн журмаар тогтоох бөгөөд ихэвчлэн 1 жилийн хугацаатай ажиллахаар тогтоосон байдаг. Тухайлбал: Ханян Их Сургуулийн “Сургалтын төлбөрийн хяналтын хорооны дүрэм”-д хорооны гишүүдийг 1 жилийн хугацаатай ажиллуулахаар журамласан байна.

Солонгосын Засгийн газар их, дээд сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах үүднээс дээд боловсролын байгууллагуудад тэтгэмж олгох өрсөлдөөнд тулгуурласан механизмыг бий болгосон. 1992 оноос хойш боловсролын салбарт чанарын үнэлгээ хийхэд үнэлгээний болон магадлан итгэмжлэлийн байгууллагуудыг ашиглах болсон. Эдгээр байгууллагуудын үнэлгээгээр эхний 10-т орсон сургалтын байгууллагууд нь санхүүгийн дэмжлэг авах, нормативт элсэгчдийн тоогоо нэмэгдүүлэх зэрэг тодорхой дэмжлэг авдаг байна. Одоогоор төрийн болон хувийн хэвшлээс үл хамааран Засгийн газраас олгодог судалгааны санхүүжүүлтийн 46 орчим хувийг шилдэг 10 сургуульд олгож байна. Шилдэг 10 их сургуулийн 8 нь хувийн хэвшлийн их сургууль байна.

Солонгос улс нь кредит цагийн системтэй бөгөөд сургалтын төлбөрийн хэмжээг салбарын яамнаас тогтоодог.

*/Улсын болон хувийн сургуулийн төлбөрийн мэдээллийг 2016 оны байдлаар дараах хүснэгтээс үзнэ үү. /*

12 Higher education law

/http://www.moleg.go.kr/english/korLawEng.jsessionid=N8rtIMXT6nkiiKgZ3DnKMKIeeWiaiiXw7RUXnMmfzHs3mnZTef15GdovVtliQ1AI.moleg\_a2\_servlet\_engine2?pstSeq=52250&pageIndex=57/

13 대학 등록금에 관한 규칙, <http://www.law.go.kr/lsBdyPrint.do#AJAX>

## БНСУ-ын төрийн болон хувийн сургуулийн төлбөрийн мэдээлэл

Их сургуулийн төрөл	Салбар	Боловсролын түвшин	1 жилийн сургалтын төлбөрийн хэмжээ /ам.доллар/
Улсын сургуулийн сургалтын төлбөр	Хүмүүнлэгийн салбар	Баклавр	2000-2300
		Магистр, доктор	2500-2700
	Шинжлэх ухаан	Баклавр	2500-2800
		Магистр, доктор	3000-3300
	Соёл урлаг	Баклавр	2800-3000
		Магистр, доктор	4300-4400
	Эмнэл зүй	Баклавр	4300-4400
	Магистр, доктор	4000-5100	
Хувийн сургуулийн сургалтын төлбөр	Хүмүүнлэгийн салбар	Баклавр	\$3,800 ~ \$4,000
		Магистр, доктор	\$4,000 ~ \$5,000
	Шинжлэх ухаан	Баклавр	\$5,000 ~ \$6,000
		Магистр, доктор	\$4,000 ~ \$5,000
	Соёл урлаг	Баклавр	\$5,000 ~ \$6,000
		Магистр, доктор	\$5,000 ~ \$6,000
	Эмнэл зүй	Баклавр	\$6,500 ~ \$7,000
	Магистр, доктор	-	

БНСУ-д төрөөс дотоодын оюутнууддаа сургалтын тэтгэлэг, болон сургалтын зээл хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг ба ингэхдээ оюутны чадвар өолон санхүүгийн чадамжийг чухалчлан авч үздэг. Оюутны тэтгэлгийг их, дээд сургуулиуд дотоод журам болон суралцаж буй мэргэжлийн чиглэл онцлогоос хамааруулан ялгавартайгаар тогтоодог байна.

БНСУ-д гадаадын болон дотоодын оюутнуудад дараахь тэтгэлгүүдийг олгодог байна. Үүнд:

- БНСУ-ын Засгийн газрын бакалаврын тэтгэлэг,
- БНСУ-ын Засгийн газрын урилгаар суралцуулах магистр, докторын тэтгэлэг олгох тусгай хөтөлбөр,
- БШУТЯ-наас зарласан баклаврын зэрэгт суралцуулах Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр,
- Зүүн Азийн урлагийн мэргэжилтэнд зориулсан тэтгэлэг,
- Солонгосын дээд боловсролын сангаас зарладаг олон улсын эрдэм шинжилгээний солилцоог дэмжих хөтөлбөр<sup>14</sup> зэрэг тэтгэлгүүдийг олгож байна.

БНСУ-ын дотоодын оюутнуудад олгодог тэтгэлэг, дэмжлэгүүд :

- Багш, профессоруудын саналаар хамгийн сайн суралцаж буй оюутнуудыг сургалтын төлбөрөөс 30% хүртэлх хувиар чөлөөлөх,
- Нийт суралцаж буй дотоодын оюутнуудын тодорхой хувийг /45-75%/ ямар нэгэн хэмжээгээр тэтгэлэг, хөнгөлөлтөнд хамруулах

14 Study in Korea- <http://www.studyinkorea.go.kr/mn>

- Нийт суралцагч оюутнуудын 30% хүртэлх хувийг багшийн санал болгосноор 100%-ийн сургалтын төлбөрөөс чөлөөлөх. Ингэхдээ 2 хэлбэрээр тэтгэлэг олгох ба А/ сургалтын төлбөрөөс бүрэн чөлөөлж сарын 800.000 вонны стипенд олгоно, В/ сургалтын төлбөрөөс 50%- чөлөөлнө. Энэхүү тэтгэлэгийг сурлагын амжилт гаргасан оюутанд өгдөг ба тухайн оюутны суралцаж буй салбар чиглэлээс хамааран ялгавартай тогтоодог.



Монгол Улсын Их сургуулиудын төлбөрийн мэдээлэл<sup>15</sup>

№	Сургуулийн нэр	1 дамжаа	2 дамжаа	3 дамжаа	4 дамжаа	Дундаж төлбөр /сая.төг/
1	МУИС	81600	72700	72700	56600	1.7
2	ХААИС	66600	66000	66000	66000	1.98
3	АШУУИС	70000	65000	65000	55500	2.0
4	ШУТИС	58500	58500	58500	58500	1.7
5	СУИС	46600	46600	46600	46600	1.4
6	МУБИС	65000	58000	58000	58000	1.74
7	БХИС	43000	40000	36600	33300	1.0

## Хувийн их дээд сургуулиудын төлбөрийн мэдээлэл

№	Сургуулийн нэр	Төлбөрийн хэмжээ
1	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	1500000
2	Их засаг их сургууль	990000
3	Орхон их сургууль	1200000
4	Отгонтэнгэр их сургууль	1040000
5	Монгол бизнес дээд сургууль	875000
6	Мандах бүртгэл дээд сургууль	1300000
7	Улаанбаатар дээд сургууль	900000
8	Санхүү эдийн засгийн дээд сургууль	1900000
9	Оточ манрамба дээд сургууль	1500000
10	Төмөр замын дээд сургууль	850000
11	Шихихутаг хууль зүйн дээд сургууль	1200000
12	Сэрүүлэг дээд сургууль	980000
13	Тэнгэр дээд сургууль	850000
14	Идэр дээд сургууль	1380000
15	Газарчин дээд сургууль	800000-950000
16	Улаанбаатар-Эрдэм Оюу дээд сургууль	900000-950000
17	Их Монгол дээд сургууль	850000
18	Гурван эрдэнэ багшийн дээд сургууль	850000
19	Соёмбо дээд сургууль	700000
20	Чингис хаан дээд сургууль	795000
21	Монголын үндэсний дээд сургууль	895000-995000
22	Сутай дээд сургууль	880000
23	Монгол дээд сургууль	750000
24	Шинэ иргэншил дээд сургууль	500000
25	Аварга дээд сургууль	750000

15 Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамнаас ирүүлсэн мэдээлэл, 2016.04.15

26	Ач дээд сургууль	1000000
27	Сити дээд сургууль	1500000
28	Хөдөлмөрийн дээд сургууль	950000
29	Олон улс судлалын дээд сургууль	950000-1050000
30	Хангай дээд сургууль	760000
31	Этүгэн дээд сургууль	1500000
32	Хүрээ дээд сургууль	1125000
33	Зохиомж дээд сургууль	1150000
34	Хэл иргэншлийн дээд сургууль	979000
35	Соёл-Эрдэм коллеж	1025000
36	Мон-Алтиус биеийн тамирын дээд сургууль	790000
37	Утга зохиол нийгмийн ажилтны коллеж	790000
38	Энх-Орчлон коллеж	770000

### Хувийн хэвшлийн ЕБС-ийн төлбөрийн мэдээлэл

№	Дүүрэг	Сургуулийн нэр	Нийт хүүхэд	Төлбөр		
				Бага	Дунд	Ахлах
1	Чингэлтэй	Бэтүв	35	-	-	-
2	Чингэлтэй	Зуунбилиг	160	2,000,000	2,000,000	2,500,000
3	Чингэлтэй	Наран	203	1,500,000	1,800,000	1,800,000
4	Чингэлтэй	Чинхур	120	950,000	950,000	950,000
5	Чингэлтэй	Цахим-Эрин	31	780,000	980,000	980,000
6	Чингэлтэй	Тусгал	79	1,260,000	1,270,000	1,290,000
7	Чингэлтэй	Тоолол	40	-	-	800,000
8	Чингэлтэй	Олонлог	615	4,500,000	4,500,000	4,500,000
9	Чингэлтэй	Атланта	106	1,250,000	1,600,000	1,600,000
10	Баянгол	Билэг Оюу	110	1,500,000	1,600,000	1,800,000
11	Баянгол	Гурван тамир	362	1,800,000	1,800,000	1,800,000
12	Баянгол	Жаргалан	332	1,750,000	1,800,000	1,850,000
13	Баянгол	Ирээдүй	13	1,000,000	-	-
14	Баянгол	Лидер	86	1,050,000	1,200,000	1,500,000
15	Баянгол	Номч	55	1,300,000	1,500,000	1,800,000
16	Баянгол	Номун далай	74	700,000	800,000	800,000
17	Баянгол	Онол	6	1,300,000	-	-
18	Баянгол	Оюуны төв	105	1,800,000	1,900,000	2,000,000
19	Баянгол	Оюуны нахиа	165	1,500,000	1,600,000	1,800,000
20	Баянгол	Хүрээ тулга	293	1,200,000	1,350,000	1,500,000
21	Баянгол	Хүслийн өргөө	215	1,800,000	1,800,000	1,800,000
22	Баянгол	Радуга	444	1,950,000	1,950,000	1,950,000
23	Баянгол	Русская гимназия	131	3,600,000	4,100,000	4,600,000
24	Баянгол	Сентпоул		Халамжийн сургууль		
25	Баянгол	Сэнлизэ	187	1,200,000	1,300,000	1,400,000
26	Баянгол	Цацраг эрдэм	15	900,000	1,000,000	1,000,000
27	Баянгол	Шатлал	18	1,100,000	1,200,000	1,300,000
28	Баянгол	Гэгээрэл	350	2,000,000	2,000,000	2,000,000
29	Баянгол	Эхлэл	185	2,000,000	2,100,000	2,200,000
30	Баянгол	Эрдмийн далай	51	1,500,000	1,800,000	2,100,000
31	Баянгол	Төгсбилэг/ Бага сургууль/	58	1,100,000	-	-
32	Баянгол	Ургах наран	50	1,200,000	1,400,000	1,400,000

33	Баянгол	Монгол коосен	100	-	-	2,000,000
34	Баянгол	Монгол Од	168	1,800,000	1,800,000	1,800,000
35	Баянзүрх	Арвис	153	1,900,000	2,200,000	2,500,000
36	Баянзүрх	Билгүүн номч	158	1,400,000	1,400,000	1,400,000
37	Баянзүрх	Билгүүн үүдэн	135	1,560,000	1,800,000	2,040,000
38	Баянзүрх	Саруул ирээдүй	103	700,000	750,000	800,000
39	Баянзүрх	Крилица	120	2,300,000	-	-
40	Баянзүрх	Эрэл И Эс Эм Олон улсын дунд сургууль	388	8,550,000	8,750,000	8,950,000
41	Баянзүрх	Оюуны оньс	57	2,100,000		
42	Баянзүрх	УБ дунд сургууль	661	1,500,000	1,500,000	1,600,000
43	Баянзүрх	Төгс дэлгэрэх	570	1,900,000	1,900,000	1,900,000
44	Баянзүрх	Шинэ Монгол	1262	2,300,000	2,400,000	2,500,000
45	Баянзүрх	Оюунлаг	639	3,000,000	2,500,000	2,500,000
46	Баянзүрх	Монгол турк	361	-	5,000,000	4,500,000
47	Баянзүрх	Хишиг	381	2,000,000	2,000,000	2,000,000
48	Баянзүрх	Хөвгүүд	135	450,000	450,000	450,000
49	Баянзүрх	Их засаг	366	2,000,000	2,000,000	2,000,000
50	Баянзүрх	УБ лицей	1004	2,770,000	3,160,000	3,550,000
51	Баянзүрх	Эрхэм баян эрдэм	79	3,000,000	3,000,000	3,000,000
52	Баянзүрх	Итгэл бүрэн	66		1,800,000	1,800,000
53	Хан-Уул	Америк	576	10,000,000	13000000	15250000
54	Хан-Уул	Аварга	192	0	0	450000
55	Хан-Уул	Орхон	126	1,550,000	1,550,000	1,550,000
56	Хан-Уул	Англи	305	13000 \$	16680 \$	17920 \$
57	Хан-Уул	Сакура	100	3,300,000	3,700,000	4,000,000
58	Хан-Уул	Орчлон	1005	11,000,000.0	12000000	12000000
59	Хан-Уул	Авьяас	30	0	680000	840000
60	Сонгинохайрхан	Батномуун	53	685,000	685,000	685,000
61	Сонгинохайрхан	Гэрэлт ирээдүй	75	-	1,300,000	1,500,000
62	Сонгинохайрхан	Онон	34	-	-	685,000
63	Сонгинохайрхан	Номуун	199	2,000,000	2,000,000	2,000,000
64	Сонгинохайрхан	Чандмань	229	500,000	500,000	600,000
65	Сонгинохайрхан	Ромашка	196	1,850,000	1,850,000	1,850,000
66	Сонгинохайрхан	Тольт	37	1,700,000	1,800,000	2,000,000
67	Сонгинохайрхан	Номын ёс	22	900,000		
68	Налайх	Хос Уянга	85	900000	0	0
69	Налайх	Чандмань Эрдэнэ	28	Төлбөргүй шашны сургууль		
70	Багануур	Сод	132	1,200,000	1,550,000	1,550,000
71	Сүхбаатар	МУИС Байгаль- Эх лицей	304			1,500,000
72	Сүхбаатар	ШУТИС Ахлах сургууль	504			3,000,000
73	Сүхбаатар	ШУТИС Коосэн загварын сургууль	55			3,000,000
74	Сүхбаатар	Кингс Кидс	242	3,000,000		
75	Сүхбаатар	Эрдэм төгс	240	1,200,000	1,200,000	1,200,000
76	Сүхбаатар	Оюуны тулга	229	2,000,000	2,500,000	2,900,000
77	Сүхбаатар	Ертөнц	260	700,000	850,000	900,000
78	Сүхбаатар	Гёте	400	2,900,000	3,000,000	2,900,000
79	Сүхбаатар	Сант	1300	5,000,000	5,000,000	6,000,000

80	Сүхбаатар	Шинэ үе	800	2,200,000	2,400,000	2,600,000
81	Сүхбаатар	Сакура	110	2,000,000	2,300,000	2,700,000
82	Сүхбаатар	Үй цай	965	3,300,000	2,600,000	2,600,000
83	Сүхбаатар	Галакси	191	1,550,000	1,380,000	1,380,000
84	Сүхбаатар	Хобби	838	5,000,000	6,000,000	7,000,000
85	Сүхбаатар	Монгол Хятад найрамдал	504	1,800,000	1,800,000	1,800,000
86	Сүхбаатар	АВЦ ахлах сургууль	20			850,000
87	Сүхбаатар	Шонхор	40			390,000
88	Сүхбаатар	Авъяас	28		680,000	840,000
89	Сүхбаатар	Соёмбо	129	2,000,000		
90	Сүхбаатар	Болор	68	1,350,000	1,350,000	1,350,000
91	Сүхбаатар	Логарифм	365	3,000,000	2,600,000	
92	Сүхбаатар	Искра	104	488,000	588,000	688,000
93	Сүхбаатар	Хүлэг	74	1,540,000	1,680,000	1,820,000
94	Сүхбаатар	Улаанбаатар элит	285	8,900,000	10,500,000	11,900,000
95	Сүхбаатар	Шинэ зууны удирдагч	58			1,800,000
96	Сүхбаатар	Хөгжлийн гүүр	20			2,500,000
97	Сүхбаатар	Сод-Эрдэм	50	1,500,000	1,800,000	2,000,000
98	Сүхбаатар	Ес Эрдэм	121	1,500,000	1,500,000	1,500,000
99	Сүхбаатар	Шилдэг	8	2,500,000		

## Ашигласан материал

1. Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 37 зүйл зүйл
2. Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамнаас ирүүлсэн мэдээлэл, 2016.04.15
3. Education chart, <http://pharmawiki.in/education-system/>
4. 1998 Amendments to the Higher Education Act, <http://www2.ed.gov/policy/highered/leg/hea98/index.html>
5. TEQSA, <http://www.teqsa.gov.au>
6. Education Services for Overseas Students , <http://www.esos.curtin.edu.au>
7. Tertiary Education Quality and Standards Agency Act /2011/, <https://www.legislation.gov.au/Details/C2015C00622>
8. Department Of Education and Training, <https://www.education.gov.au/>
9. Higher Education Act /2013/, <https://www.legislation.gov.au/Details/C2013A00067>
10. [https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment\\_data/file/219167/v01-2012ukes.pdf](https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/219167/v01-2012ukes.pdf)
11. <http://www.learnenglish.de/culture/educationculture.html#primary>
12. <http://www.euroeducation.net/prof/ukco.htm>
13. <http://www.hefce.ac.uk/pubs/year/2016/201603/>
14. Higher education law, <http://www.moleg.go.kr/english/korLawEng>
15. 대학 등록금에 관한 규칙, <http://www.law.go.kr/lsBdyPrint.do#AJAX>
16. <http://smcs.num.edu.mn/files/2013/DeedBolosrolSudalgaa/Deed%20bolovsrolyn%20bodlogyn%20shinjilgee-1.pdf> -Дээд боловсролын бодлогын шинжилгээ
17. <http://www.must.edu.mn/mn/pdf/3180recom-CDIO-OBE%20program%20development-14-05-15.pdf> Үр дүнд суурилсан сургалт-ын аргад үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж
18. [https://sisi.num.edu.mn/files/ZHSHUA/Juram/Bakalavryn%20surgaltyn%20juram\\_New.pdf](https://sisi.num.edu.mn/files/ZHSHUA/Juram/Bakalavryn%20surgaltyn%20juram_New.pdf) МУИС-ийн бакалаврын сургалтын журам
19. <http://www.cmuc.edu.mn/index.php/page?id=1> -Дээд боловсролын шинэчлэл- Солонгос
20. <https://sisi.num.edu.mn/files/ZHSHUA/Juram/Shine%20strategi%20plan.pdf> -МУИС-ийн 2020 он хүртэлх хөгжлийн шинэчилсэн стратеги төлөвлөгөө /2011-2020/
21. <http://www.meds.gov.mn/>-Дээд боловсролын шинэчлэлийн зураглал 2010-2021
22. <http://www.news.mn/content/175005.shtml> Дээд боловсролын чанарын шинэчлэлийн суурь шийдэл
23. <http://www.meds.gov.mn/data/1501/higher.pdf> -Дээд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого
24. <http://www.slideshare.net/ambuk2006/ss-14977486>  
<http://www.hefce.ac.uk/pubs/year/2016/201603/>
25. [http://www.ukpublicspending.co.uk/uk\\_budget\\_detail\\_15bt12014n\\_20#ukgs303](http://www.ukpublicspending.co.uk/uk_budget_detail_15bt12014n_20#ukgs303)
26. <http://www.euroeducation.net/prof/ukco.htm>
27. [https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment\\_data/file/219167/v01-2012ukes.pdf](https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/219167/v01-2012ukes.pdf)
28. <http://www.learnenglish.de/culture/educationculture.html#primary>